



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/10 ДУГААР-2018/122/СТА-ТЦЦЗ

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зардлыг зориулалт бусаар зарцуулсан 240000.00 /Хоёр зуун дөчин мянган / төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Үндсэн цалингийн зардлаас 240000.00 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаал /Үндсэн цалин-цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана/ гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар баглагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, дотоод хяналтыг сайжруулах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 02 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төвийн төсвийн шууд захирагч Ш.Энхсүх, нягтлан бодогч А.Соёл-эрдэнэ нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫН**

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР  Р.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ  Ш.ЭНХСҮХ  
НЯГТЛАН БОДОГЧ А.СОЁЛ-ЭРДЭНЭ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цэг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил заргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.